

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/49/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай хот
2022 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: dagvasurend@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.2.1 Залруулсан алдаа	13
4.2.2 Төлбөрийн акт	13
4.2.3 Албан шаардлага	13
4.2.4 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.24 № 1302/250

танай _____ -ны № _____ -т

ЯРУУ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.АМГАЛАНБААТАР-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Яруу сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- 30.5 сая төгрөгийн гүйлгээг санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар төлбөрийн хүсэлтэнд гарын үсэг, тэмдэг дараагүй, анхан шатны баримтанд тэмдэг дарж баталгаажуулан гүйлгээ хийгээгүй;
- Санхүүгийн албаны даргын хувийн дансанд бичиг хэрэг, шатахуун, самбар, галын түлээ худалдан авах зориулалттай 5.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 1.0 сая төгрөгөөр самбар хийхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй;
- Төрийн банкны 172300095263 тоот харилцах дансанд үр дүнгийн урамшуулал олгосон, бичиг хэрэг, шатахуун, сэлбэг, аж ахуйн материал худалдан авах зориулалттай нийт 19.6 сая төгрөг төвлөрүүлсэн. Уг дансанд түрээсийн 1.3 сая төгрөгийн орлого, ОНХСангийн гэрэлтүүлгийн зардал 2.0 сая төгрөгийн санхүүжилт, ИТХурлаас хуралдааны болон материалын зардал 2.3 сая төгрөг төвлөрүүлсэн;
- Нярае бараа материалын тайлан гаргаж тооцоо бодоогүй, мөнгөн кассын тайлан гаргаагүй, дээрх данснаас 200.0 мянган төгрөгийг дутагдуулсан;
- Тус сумын ИТХ-ын дарга Ш.Шижирт 100.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон;
- 3.6 сая төгрөгийн зардалд ө-баримт бүрдүүлээгүй;

Эдгээр зөрчил нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6 "Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө. Төлбөрийн хүсэлтийн 1 хувь Төрийн

010025209

санд үлдэнэ.” 8.7. “Төсвийн байгууллага нь төлбөрийн хүсэлтийн үндэслэх баримтуудад Төрийн сангийн тэмдэг дарагдсан эсэхийг гүйлгээ хийсэн тухай бүр хянаж байна”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай уулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5997072.00	3207203.00
33	АВЛАГА	0.00	76051.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	76051.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5997072.00	3131152.00
351	Түүхий эд материал	0.00	0.00
354	Хангамжийн материал	5997072.00	3131152.00
35410	Бичиг хэргийн материал	265000.00	655000.00
35420	Аж ахуйн материал	2214072.00	1866152.00
35440	Түлш, шатах тослох материал	2300000.00	0.00
35450	Барилгын засварын материал	608000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	610000.00	610000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	407451083.80	395646186.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	407451083.80	395646186.00
392	Биет хөрөнгө	399695583.80	388220686.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	439989675.50	439989675.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-117325680.65	-133461697.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	139730550.00	139730550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100742629.82	-107401589.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	173470593.39	191851793.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150513844.93	-157941063.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29937878.56	33351878.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23741277.55	-25668306.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	27934579.00	27934579.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19044259.70	-20165134.26
393	Биет бус хөрөнгө	7755500.00	7425500.00
39301	Програм хангамж	2802000.00	2802000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1344500.00	-1674500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6298000.00	6298000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	413448155.80	398853389.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	816031.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	816031.00	0.00
413	Өглөг	816031.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	816031.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	412632124.80	398853389.00
51	Засгийн газрын хувь оролцоо	412632124.80	398853389.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	312259773.46	312259773.46
51101	Өмч: - төрийн	312259773.46	312259773.46
512	Хуримтлагдсан үр дүн	-32377840.57	-46156576.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-41993735.21	-32377840.57
51220	Тайланг үеийн үр дүн	9615894.64	-13778735.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	132750191.91	132750191.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	413448155.80	398853389.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	427120094.00	347150015.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44903694.00	6000000.00
120	Нийтлэг татварын бус орлого	40135520.00	6000000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40135520.00	6000000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40135520.00	6000000.00
122	Тусламжийн орлого	4768174.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	4768174.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	382216400.00	341150015.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382216400.00	328739200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382216400.00	328739200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	12410815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	12410815.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	417504199.36	359628750.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417504199.36	359628750.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380469120.36	354432833.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232117742.00	221413259.10
210101	Үндсэн цалин	213343192.00	205599496.10
210105	Гэрээт ажлын хөлс	18774550.00	15813763.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27509483.00	27478693.00
210201	Тэтгэврийн даатгал	19403585.00	19614591.00
210202	Тэтгэмжийн даатгал	2282774.00	2172512.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1826219.00	1738007.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363356.00	359417.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3633549.00	3594166.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19358400.00	17548400.00
210301	Гэрэл, цахилгаан	1788400.00	1708400.00
210302	Түлш, халаалт	17570000.00	15840000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27680456.00	23879620.00
210401	Бичиг хэрэг	2782100.00	2169600.00
210402	Тээвэр, шатахуун	20176856.00	14418300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2846000.00	2267800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1875500.00	5023920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20458710.00	6348200.00
210604	Урсгал засвар	20458710.00	6348200.00
2107	Томилголт, зочны зардал	3174300.00	2458500.00
210702	Догоод албан томилголт	3174300.00	2458500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6939943.00	5206064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5655619.00	4069764.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	227700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	22000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246400.00	153400.00
210807	Газрын төлбөр	31492.00	32000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3732.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43230086.36	50100097.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5981630.00	16500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25300.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37223156.36	33600097.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37035079.00	5195916.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	36977800.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36977800.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57279.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57279.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	5195916.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5195916.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9615894.64	-12478735.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9615894.64	-12478735.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-41,993,735.21	0.00	403,016,230.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-41,993,735.21	0.00	403,016,230.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	9,615,894.64	0.00	9,615,894.64
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-32,377,840.57	0.00	412,632,124.80
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-32,377,840.57	0.00	412,632,124.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-32,377,840.57	0.00	412,632,124.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	312,259,773.46	132,750,191.91	-32,377,840.57	0.00	412,632,124.80
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-13,778,733.94	0.00	-13,778,733.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-46,156,574.51	0.00	398,853,390.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386984574.00	341150015.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4768174.00	0.00
122	Тусламжийн орлого	4768174.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	4768174.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382216400.00	341150015.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382216400.00	328739200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382216400.00	328739200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	12410815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	12410815.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	369589574.00	319378815.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369589574.00	319378815.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332554495.00	314182898.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232117740.00	22073365.10
210101	Үндсэн цалин	213343192.00	206568628.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	24515.00
210105	Гэрээт ажлын хөлс	18774548.00	15480222.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26689126.00	27634618.00
210201	Тэтгэврийн даатгал	18681293.00	19741729.00
210202	Тэтгэмжийн даатгал	2220176.00	2144078.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1796138.00	1715262.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425616.00	363295.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3565903.00	3670254.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13448400.00	15248400.00
210301	Гэрэл, цахилгаан	1788400.00	1708400.00
210302	Түлш, халаалт	11660000.00	13540000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25459456.00	18695700.00
210401	Бичиг хэрэг	2326600.00	2509600.00
210402	Тээвэр, шатахуун	20176856.00	13918300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2956000.00	2267800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17940500.00	5740200.00
210604	Урсгал засвар	17940500.00	5740200.00
2107	Томилголт, зочны зардал	3174300.00	2458500.00
210702	Дотоод албан томилолт	3174300.00	2458500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7046943.00	5832115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5655619.00	4645815.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	227700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	22000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353400.00	203400.00
210807	Газрын төлбөр	31492.00	32000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3732.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6678030.00	16500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6374630.00	16500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303400.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37035079.00	5195916.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	36977800.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36977800.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57279.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57279.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох гатаас, санхүүжилт	0.00	5195916.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5195916.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17395000.00	21771200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17395000.00	20471200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17395000.00	20471200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17395000.00	20471200.00
223001	Бусад хөрөнгө	0.00	4676000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17395000.00	15795200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17395000.00	-20471200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	1300000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338724400.00	323543283.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338724400.00	323543283.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338724400.00	323543283.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232218500.00	222073365.10
210101	Үндсэн цалин	211417700.00	206568628.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	24515.00
210105	Гэрээг ажлын хөлс	20800800.00	15480222.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31349500.00	27634618.00
210201	Тэтгэврийн даатгал	22060800.00	19741729.00
210202	Тэтгэмжийн даатгал	2322200.00	2144078.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1857700.00	1715262.00
210204	Ажилгүйдлийн даатгал	464500.00	363295.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4644300.00	3670254.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15248400.00	15248400.00
210301	Гэрэл, цахилгаан	1788400.00	1708400.00
210302	Түлш, халаалт	13460000.00	13540000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18573600.00	18154200.00
210401	Бичиг хэрэг	2509600.00	2509600.00
210402	Тээвэр, шатахуун	13094300.00	13094300.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	2969700.00	2550300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19885200.00	11885200.00
210604	Урсгал засвар	19885200.00	11885200.00
2107	Томилолт, зочны зардал	3185700.00	2458500.00
210702	Дотоод албан томилолт	3185700.00	2458500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5560100.00	5386300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4200000.00	4200000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232100.00	232100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469100.00	469100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227700.00	227700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73800.00	22000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203400.00	203400.00
210807	Газрын төлбөр	138300.00	32000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15700.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12703400.00	20702700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3500000.00	11500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9203400.00	9202700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	338724400.00	323543283.10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338724400.00	323543283.10
122005	Орон нутгийн төсвөөс	338724400.00	323543283.10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	11110815.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	6434815.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	6434815.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	824000.00
210402	Тээвэр, шатахуун	-	824,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	610815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	610,815.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	5000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	4676000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	4676000.00
223001	Бусад хөрөнгө	-	4,676,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	11110815.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	11110815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,110,815.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 1/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Яруу сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 347,150.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,207.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,905.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	76.0	76.0
Бараа материал	5,997.1	3,131.1	(2,866.0)
Үндсэн хөрөнгө	407,451.0	395,646.2	(11,804.8)
Нийт хөрөнгө	413,448.1	398,853.3	(14,594.8)
Өр төлбөр	816.0	-	(816.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	412,632.1	398,853.3	(13,778.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	413,448.1	398,853.3	(14,594.8)

Авлага дансны үлдэгдэл 76.0 мянган төгрөг болж өссөн нь ажилчилтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 2,866.0 мянган төгрөгөөр буурсан нь материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,804.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 816.0 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд өмнөх оны өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,778.8 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 338,739.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 338,739.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 328,739.2 мянган төгрөг, нэмэлт дансаар 12,410.8 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 320,678.8 мянган төгрөгийг зарцуулж, 6,495.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны гүйцэтгэлд тээвэр шатахуунд 500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 610.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,000.0 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 1,300.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 5,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн албаны дарга өөрийн нэрийн дансандаа 1,000.0 мянган төгрөгийг самбар хийхээр төлөвлөн авсан боловч хэрэгжүүлээгүй, нярав харилцах данснаасаа 200.0 мянган төгрөгийг дутагдуулсан, ИТХ-ын даргад 100.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон, Санхүүгийн албаны дарга бичиг хэрэг болон шатахуун, аж ахуйн материалын зардлаас 4,890.4 мянган төгрөгийг өөрийн нэрийн дансанд төвлөрүүлэн, зарцуулсан, санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар анхан шатны баримтгүй, гарын үсэг, тэмдэггүй төлбөрийн хүсэлтээр 30,500.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, нярвын Төрийн банкин дахь 172300095263 тоот хувийн харилцах данс руу үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон, бичиг хэрэг, шатахуун, сэлбэг, аж ахуйн материал худалдан авах зориулалттай нийт 19,600.0 мянган төгрөг төвлөрүүлэн, зарцуулсан, нярвын бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй, орлогод бүртгэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, зарцуулалтыг шаардах хуудсаар олгоогүй, замын хуудасны иж бүрдэл дутуу, шатахууны тооцоог тухай бүр бодож хариуцсан албан хаагчдаар гарын үсэг зуруулаагүй, мөн кассын үйл ажиллагааны тайланг дутуу гаргасан, цаг хугацаандаа эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй зэрэг зөрчил үйл ажиллагаанд зарцуулсан, зарцуулалтыг үнэн зөв тайлагнаагүй, нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 135 мэдээллийг хугацаандаа оруулсан бөгөөд хугацаа хоцроосон 14 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нярвын нэрийн дансанд төсвийн мөнгө төвлөрүүлэн, зориулалт бус зарцуулалт гаргасан эсэх.
- Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан эсэх.
- Нярав бараа материалын тайлан тооцоо гаргаж, цаг хугацаандаа эд хөрөнгийн тооллогыг хийсэн эсэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 69,333.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.00 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,300.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 54,990.4 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13,042.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулгын алдаа гараагүй болно.

4.2.2 Төлбөрийн акт

- Санхүүгийн албаны дарга өөрийн нэрийн дансандаа 1,000.0 мянган төгрөгийг самбар хийхээр төлөвлөн авсан боловч хэрэгжүүлээгүй;
- Нярав харилцах данснаасаа 200.0 мянган төгрөгийг дутагдуулсан;
- ИТХ-ын даргад 100.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон зэрэг зөрчил илэрсэн.

4.2.3 Албан шаардлага

- Санхүүгийн албаны дарга бичиг хэрэг болон шатахуун, аж ахуйн материалын зардлаас 4,890.4 мянган төгрөгийг өөрийн нэрийн дансанд төвлөрүүлэн, зарцуулсан;
- Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар анхан шатны баримтгүй, гарын үсэг, тэмдэггүй төлбөрийн хүсэлтээр 30,500.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн;
- Няравын Төрийн банкин дахь 172300095263 тоот хувийн харилцах данс руу үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон, бичиг хэрэг, шатахуун, сэлбэг, аж ахуйн материал худалдан авах зориулалттай нийт 19,600.0 мянган төгрөг төвлөрүүлэн, зарцуулсан;
- Няравын бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй, орлогод бүртгэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, зарцуулалтыг шаардах хуудсаар олгоогүй, замын хуудасны иж бүрдэл дутуу, шатахууны тооцоог тухай бүр бодож хариуцсан албан хаагчдаар гарын үсэг зуруулаагүй, мөн кассын үйл ажиллагааны тайланг дутуу гаргасан, цаг хугацаандаа эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2020 онд нийлүүлэгдсэн “Си-Ту-Эс” ХХК-аас 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Си-Ту-Эс” ХХК-аас худалдан авсан 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх.

2 Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд шийдвэргүй үндсэн хөрөнгө 7,792.7 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3 дахь заалтыг мөрдөн ажиллах.

3 НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллага болон иргэнд төлсөн төлбөрийн баримтгүй /и-баримт/ ажил гүйлгээ гаргасан 3,600.0 мянган төгрөг байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		10	69,333.1			4	54,990.4	3	1,300.0	3	13,042.7
	Дүн	10	69,333.1			4	54,990.4	3	1,300.0	3	13,042.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн										

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Д.БАТ-УНДРАА	2022.02.25
АХЛАХ АУДИТОР	Б.ДАГВАСҮРЭН	2022.02.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	Г.БААСАНЖАРГАЛ	2022.02.25
---------	----------------	------------